

АШИГЛАХ ЗААВАР

Нэвтрэлт:

- ❖ Нэг удаагийн кодоор нэвтрэх
 1. Регистрийн дугаараа оруулна
 2. Нууц үг оруулна (Энэ нь таны оруулсан том жижиг үсэг, цифрүүд агуулсан 8 буюу түүнээс дээш орон бүхий тэмдэгтүүдээс бүтсэн нууц үг байна.)
 3. “Нэвтрэх” товчин дээр дарсны дараа дэлгэц дээрх 6 оронтой кодыг та бүртгэлтэй гар утасны дугаараасаа 130092 тусгай дугаарт зурвас илгээж “Үргэлжлүүлэх” товчийг дарснаар системд нэвтэрнэ.
- ❖ Банкны эрхээр нэвтрэх:
 1. Та дараах банкуудаас өөрийн нэр дээр бүртгэлтэй банкийг сонгон орж интернэт банкныхаа нэвтрэх нэр болон нууц үгийг оруулна
 2. Үүний дараа банк танаас таны мэдээллийг ХУР системтэй хуваалцахыг зөвшөөрч буйг баталгаажуулсан асуулт асуух ба “Зөвшөөрөх” товчин дээр дарснаар та системд нэвтрэх боломжтой.
- ❖ Тоон гарын үсгээр нэвтрэх:
 1. Тоон гарын үсэг эзэмшигчийн регистрийн дугаарыг оруул
 2. Тоон гарын үсгийн E-SIGN клиент программыг суулгасан байх.
 3. E-SIGN клиент програм суулгасны дараа Нэвтрэх товчин дээр дарна.
 4. Үүний дараа И-Токен пин код оруулах цонх гарч ирэх бөгөөд нууц үгээр оруулан “Үргэлжлүүлэх” товчийг дарснаар системд нэвтэрнэ.

Бүртгүүлэх:

- ❖ Гар утсаар бүртгүүлэх заавар:
 1. Өөрийн регистрийн дугаарыг оруулна.
 2. Таны нэр дээрх монголын аль ч үүрэн холбоон дахь өөрийн бүртгэлтэй утасны дугаарыг оруулна.
 3. Дурын нууц үгээ оруулах (Ингэхдээ заавал том, жижиг үсэг болон цифр агуулсан 8 буюу түүнээс дээш орон бүхий тэмдэгт ашиглаарай.)
 4. Дурын нууц үгээ дахин оруулна
 5. Баталгаажуулалт хэсэгт доорх зурган дээрх тэмдэгтийг оруулан “Бүртгүүлэх” товчийг дарна.
Үүний дараа дэлгэц дээрх 6 оронтой кодыг бүртгэлтэй утасны дугаараасаа 130092 тусгай дугаарт зурвас илгээж баталгаажуулж үргэлжлүүлэх товчийг

дарснаар та цаашид Нэг удаагийн кодоор нэвтрэх эрхтэй болно.

❖ Банкны эрхээр бүртгүүлэх:

1. Та дараах банкуудаас өөрийн нэр дээр бүртгэлтэй банкийг сонгон орж интернэт банкныхаа нэвтрэх нэр болон нууц үгийг оруулна.
2. Үүний дараа банк танаас таны мэдээллийг ХУР системтэй хуваалцахыг зөвшөөрч буйг баталгаажуулсан асуулт асуух ба “Зөвшөөрөх” товчин дээр дарснаар та системд бүртгүүлэх боломжтой.

Нууц үг сэргээх хэсэг:

1. Өөрийн регистрийн дугаараа оруулсны дараа доорх зурган тэмдэгтийг тайлж, талбар хэсэгт бөглөөд “Нууц үг сэргээх” товчийг дарна.
2. Бүртгэлтэй гар утасны дугаараасаа 130092 тусгай дугаарт 6 оронтой кодыг зурвасаар илгээнэ.
3. Шинээр нууц үгээ зохион харгалзах талбарт оруулан “цааш” товчийг дарснаар нууц үг солигдоно.

Утасны дугаар солих:

1. Өөрийн регистрийн дугаарыг оруулна.
2. Солих утасны дугаараа оруулна. (Ингэхдээ заавал өөрийн нэр дээр бүртгэлтэй утасны дугаарыг оруулна.)
3. Зурган талбар дахь тэмдэгтийг тайлж оруулна.
4. “Дугаар солих” товчин дээр дарснаар таны шинээр сольсон утасны дугаараасаа 130092 тусгай дугаарт 6 оронтой кодыг илгээснээр солих боломжтой.

Тоон гарын үсгээр нэвтрэх:

❖ Токен төхөөрөмж ашиглан нэвтрэх:

Гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон ямарч төхөөрөмж дээр суулгасан тоонгарын үсгээр нэвтрэхэд “ESIGN” клиент программыг татсан байх шаардлагатай.

1. Регистрийн дугаараа оруулаад “Тоон гарын үсгээр нэвтрэх” товч дээр дарна.
2. “ESIGN” клиент программ нээгдэж төхөөрөмжийн пин кодоо оруулснаар системд нэвтэрнэ.

❖ Симд суурилсан тоон гарын үсгээр нэвтрэх:

1. “Симд суурилсан тоон гарын үсэг” гэсэн сонголтыг сонгоно.

2. Регистрийн дугаар болон утасны дугаараа оруулаад “Тоон гарын үсгээрнэвтрэх” товч дээр дарна.
 3. Сим байрлах гар утсанд мэдэгдэл ирж зөвшөөрөх дарснаар системд нэвтэрнэ.
- ❖ Клауд тоон гарын үсгээр нэвтрэх:
Клауд тоон гарын үсгээр нэвтрэхэд Улсын бүртгэлийн ерөнхий газрын “**GSign**” программыг гар утсандаа суулгасан байх шаардлагатай.
1. “Клауд тоон гарын үсэг” гэсэн сонголтыг сонгоно.
 2. Регистрийн дугаар болон утасны дугаараа оруулаад “Тоон гарын үсгээрнэвтрэх” товч дээр дарна.
 3. “GSign” программ руу орж пин кодоо оруулснаар системд нэвтэрнэ.